

## ГАРЧИГ

Д.Д	НЭР	ХУУДАСНЫ ДУГААР
1	Төслийн товч танилцуулга	3
2	Уурхайн технологийн хэсэг	8
3	Эцсийн бүтээгдэхүүний агуулах ба дахин ачилт	10
4	Дэд бүтэц удирдлага зохион байгуулалт	10
5	Байгаль орчны нөхөн сэргээлт	10
6	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	11
7	Байгаль орчны менежментийн 2023 оны төлөвлөгөө	15
8	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	19
9	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлгөө	20
10	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	20
11	Түүх соёлын өв хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	20
12	Уул уурхайн төслийн БОМТ-ийн хяналтын хуудас	25

## НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Түгээмэл тархацтай ашигт малтмалын MV-015042 тоот тусгай зөвшөөрөл бүхий Зүүн эрэг элс-хайрганы хольцын орд нь засаг захиргааны хувьд Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт харьяалагдах ба Туул тосгоны зүүн урд талд Улаанбаатар хотын төвөөс баруун зүнт 20 км-т, Төв аймгийн Алтанбулаг сумын төвөөс зүүн зүнт 15 км-т, Шувуун фабрикаас зүүн урагш 4 км-т, 29.97 гектар талбайг хамран орших бөгөөд Хүснэгт №I.1-д үзүүлсэн газар зүйн солбицуудтай байна.

### Хүснэгт № I Тусгай зөвшөөрлийн газарзүйн солбицол

№	Үртраг	Өргөрөг
1	106° 37' 11.3"	47° 44' 5.78"
2	106° 37' 11.3"	47° 43' 39.31"
3	106° 37' 1.3"	47° 43' 39.31"
4	106° 37' 1.3"	47° 43' 48.77"
5	106° 36' 53.67"	47° 43' 48.77"
6	106° 36' 53.67"	47° 43' 49.85"
7	106° 36' 57.01"	47° 43' 53.29"
8	106° 36' 41.63"	47° 44' 2.51"
9	106° 36' 41.63"	47° 44' 5.33"
10	106° 36' 46.41"	47° 44' 5.33"
11	106° 36' 46.41"	47° 44' 5.78"

Газарзүйн мужалаар ордын дүүрэг нь Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харьяалагдана. Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэлд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй. Талбайн хойд, баруун хойт хэсгээр

жижиг толгодлог болон хөндий бүхий нам уулсын гадаргуу зонхилох бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө баруун, баруун хойш чиглэлд сунаж тогтсон байдаг.

Баруун урд болон баруун хойд талаар орших Бөхөг гол, Туул голын хөндий нь нилээд өргөн бөгөөд томоохон тэвш хэлбэртэй тэгшивтэр гадаргуутай аллювийн хөндийгөөс дээшлэхэд налуутар гадаргууд шилжиж пролювийн дэнж үүсгэнэ. Ойролцоо хамгийн өндөр цэг нь “Зүүн эрэг” талбайн зүүн урд орших “Жиргагч” уул 1737.3 м, хамгийн нам дор цэг нь туул голын хөндийд 1203.0 м байна. Гадаргуугын гарш илэрцийн хувьд дунд зэргийн төлөв байдалтай.

Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын дүүргээр Туул, Бөхөг, Түргэн зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг

Хүн амын суурьшил нь бусад дүүрэг нутагтай харьцуулахад маш их нягтралтай. Нутгийн оршин суугчдын ихэнхийг халх ястан эзлэх ба манай Монгол орны бүх үндэстэн, ястан оршин суудаг. Нутгийн угуул иргэд нь мал аж ахуй, газар тариалан эрхлэхийн зэрэгцээ уул уурхайн олборлох салбар болох элс-хайрга, чулууны карьерын үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудад ажилдаг.

“Зүүн эрэг” элс-хайрганы хольцын орд нь засаг захиргааны төв, улсын нийслэл Улаанбаатар хотоос баруун урагш 40 км-т, Өлзийт хороололын засмал замаас баруун зүгт 6 км-т, Биокомбинат, Шувуун фабрикийн өндөр хүчдлийн цахилгаан дамжуулах шугамаас урагш 1 км-т оршдог онцлогтой. Эдийн засгийн төвийн бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт харьялагдана. Жилийн аль ч улиралд авто замын тээврээр уг ордын дүүрэгт зорчин очих бүрэн боломжтой. Сүүлийн жилүүдийн геологийн судалгаагаар тус дүүрэгт үйлдвэрлэлийн ач холбогдолтой барилгын материалын түүхий эдийн олон ордууд нээгдэж, түүнийг түшиглэн барилгын материалын үйлдвэр, карьерийн аж ахуйнууд үйл ажиллагаагаа эхлэн явуулж байна.

Зүүн эрэг ордын барилга байгууламж, ашиглалтын үеийн үйл ажиллагаанд шаардагдах ус, эрчим хүчний хангамж, засвар үйлчилгээ зэрэг дэд бүтцийн шийдлийг энэ бүлэгт тусгалаа.

Уурхайн дэд бүтцийн үндсэн хэсэгт цахилгаан хангамж, ус хангамж, зам тээвэр, харилцаа холбооны зохион байгуулалтыг тодорхойлох шаардлагатай

бөгөөд уг ордын хувьд дэд бүтэц сайн хөгжсөн, зам харилцаа сайтай, зах зээлдээ ойрхон тул бүтээгдэхүүнээ түргэн шуурхай хүргэх боломжтой.

Орд нь Төв аймгийн Алтанбулаг сумын нутагт орших ба Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэгтэй хил залгаа байрладаг ба уурхайд шаардлагатай тоног төхөөрөмж, хүнд машин механизм хүргэх, тээвэрлэхэд ямар нэгэн хүндрэлгүй болно.

Ордын зүүн талаар 60 м зйтай Тэгш плант болон бусад компаниудын тавьсан сайжруулсан шороон замтай нийлэх бөгөөд тус зам нь хойш 1.2 км яваад Туул тосгон – Улаанбаатар чиглэлийн хатуу хучилттай авто замтай нийлдэг учир элс, хайргыг автомшинаар тээвэрлэх бүрэн боломжтой.

Сүүлийн жилүүдэд хотод суурьших хүн амын тоо өсч, хотжилт явагдаж барилга, орон сууц ихээр баригдаж байгаатай холбогдуулан барилгын материалын хэрэгцээ, түүнчлэн хайрганы хэрэгцээ жилээс жилд өссөн нэмэгдэж байна.

Энэ бүтээн байгуулалтын ажилд өөрийн хувь нэмрээ оруулах зорилоор “Жо интернэшил” ХХК нь Төв аймгийн Алтанбулаг сумын нутант Зүүн эрэг нэртэй газарт Ашигт малтмал, Газрын тосны хэрэг эрхлэх газраас олгосон MV-015042 дугаартай ашиглалтын тусгай зөвшөөрлийн дагуу түгээмэл тархацтай ашигт малтмал элс хайрга олборлох үйл ажиллагааг 2021 оноос эхлэн явуулж байна.

Ашиглалтын тусгай зөвшөөрлөөр 29,97 га талбайг 30 жилийн хугацаатай олгосон байна.

“Ашигт малтмалын тухай” хуулиар хүлээсэн ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн дагуу нөхөн сэргээлтийн ажлыг жил бүрийн ажлын төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байна.

## **II. УУРХАЙН ЖИЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ, АЖИЛЛАХ ГОРИМ, АШИГЛАХ ХУГАЦАА**

### **2.1. Уурхайн жилийн хүчин чадал**

2023 онд 50.0 мяня.<sup>3</sup> элс хайрга олборлохоор төлөвлөгөөнд тусгалаа.

### **2.2. Уурхайн ажиллах горим**

Уурхай нь 4-р сарын 1- нээс 10-р сарын 25 хүртэл 7 сар ажиллана.

Тус уурхай нь жилийн баяр ёслолын өдрүүдээс бусад бүх өдрүүдэд ажиллана.

Жилд ажиллах хоногийн тоо:

- Жилийн нийт ажиллах хоног - 214

- Баяр ёслолын хоног - 4
- Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд зарцуулах хоног - 20
- Цаг уур, нүүдэл, сэлбэгийн хангамжийн saatlaas сул зогсох хоног - 10
- Уурхайн цэвэр ажиллах хоног:  $214 - 4 - 20 - 10 = 180$  хоног
- Хоногт ажиллах ээлж – 1
- Ээлжийн үргэлжлэх хугацаа- 8 цаг

### 2.3. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

“Зүүн эрэг” элс-хайрганы холимогийн ордын хөрс хуулалт  $14.73$  мян.<sup>3</sup>, элс хайрга олборлолт  $50.0$  мян.м<sup>3</sup> бүтээгдэхүүн гаргалт  $49.15$  мян.м<sup>3</sup> ил аргаар ашиглахаар 2023 оны төлөвлөгөөнд тусгаж байна.

#### 2023 оны уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Хүснэгт №2

Cap	4	5	6	Эхний хагас жил	7	8	9	10	Сүүлийн хагас жил	Нийт
Хөрс хуулалт мян.м <sup>3</sup>	2.0	3.0	3.0	<b>8.0</b>	3.0	3.73			<b>6.73</b>	<b>14.73</b>
Элс хайрга олборлолт мян.м <sup>3</sup>	5.0	5.0	5.0	<b>15</b>	10	10	10	5.0	<b>35</b>	<b>50.0</b>

## ГУРАВ. АШИГЛАЛТЫН СИСТЕМ

### Ашиглалтын системийн сонголт

Элс-хайрганы холимогийн ордын давхаргын тогтооос хамааруулан авто тээвэртэй ашиглалтын системээр уулын ажлыг явулахаар сонгов.

#### 3.1 Уулын ажлыг гүйцэтгэх тоног төхөөрөмжийн сонголт

Уулын ажлыг “Жо интернэшил” ХХК өөрийн хөрөнгө болох тоног төхөөрөмжүүдийг түшиглэн явулахаар төлөвлөгөөнд тусгаж байна.

Төсөлд элс-хайрганы холимог олборлолт болон шимт хөрс хуулалтыг тус компаний Хятад улсад үйлдвэрлэсэн ZL 50E ачигчаар гүйцэтгэнэ. Ачигчийн техникийн тодорхойлолтыг доорхи хүснэгтэд үзүүлэв.

#### 3.2. Уурхайн тээвэр

“Зүүн эрэг” элс-хайрганы холимогийн ордын уурхайн жилийн хүчин чадал, уулын ажлыг явуулах технологиос хамааран автотээврээр тээвэрлэнэ.

#### Тээврийн тоног төхөөрөмжийн сонголт

Уурхайн элс-хайрганы холимогболон шимт хөрс тээвэрлэлтэнд БНХАУ-д үйлдвэрлэсэн HOWO ZZ3317N2861 маркийн автосамосвалыг ашиглах ба техникийн тодорхойлолтыг хүснэгт 4-д үзүүлэв.

## ДӨРӨВ. ДЭД БҮТЭЦ БА УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### 4.1. Цахилгаан эрчим хүчний үүсгүүр

Ордын цахилгаан хангамжийг Улаанбаатар – Хөшигтийн хөндий чиглэлийн замын ангийн үйлдвэрлэлийн зориулалт бүхий 10 кВ-н цахилгаан дамжуулах агаарын шугамаас салбарлуулан хангаж байна. Ил уурхайд цахилгааны дараах хэрэглэгч байна. Үүнд:

- Уурхайн хотхон
- Ангилах хэсэг
- Засварын газар болон бусад

### 4.2. Уурхайн усан хангамж

Шувуун фабрикын улсын гүний худгаас зөөвөрлөн хэрэглэнэ

Дараах усны хэрэглэгч байна. Үүнд:

- Ажилчдын унд, ахуйн хэрэглээ

## ТАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТ

### 5.1. Байгаль орчныг хамгаалах ба нөхөн сэргээлт

Монгол улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Ашигт малтмалын тухай” хууль, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хууль болон бусад тогтоол зааврын дагуу уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийг уурхайн үйл ажиллагааг явуулж байгаа байгууллага нөхөн сэргээлтийн ажлыг Монгол улсын стандарт /MNS5915:2008, MNS5916:2008, MNS5917:2008 /-ын дагуу заавал хийсэн байх үүрэгтэй.

#### Б. Техникийн нөхөн сэргээлтийн ажлын

Техникийн нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд 0.6 га талбайд дараах ажлууд хийгдэхээр төлөвлөж байна. Үүнд:

Нөхөн сэргээлтийг өөрийн нөөц бололцоо машин техник, хүн хүчид тулгуурлан ашиглалт, олборлолтын явцад үүссэн дотоод болон гадаад овоолго, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал чулуулгыг ашиглан нөхөн дүүргэлт хийх, тэгшлэх, шимт хөрсөөр хучиж биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэх, налуулах, хэвгийжүүлэх гэх мэт хэлбэрээр хийж хүрээлэн байгаа орчин, хүн майд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр засаж тохижуулна.

Хөрс хуулалттай холбоотой үүссэн овон товон гадаргууг ерөнхийд нь сийруулэн тэгшлэх, налуу гадаргууг орчных нь гадаргуутай ойртуулан хэлбэршүүлэх, ажиллагаанууд хийгдэж, дараа нь нарийвчлан хэлбэржүүлж, өнгөлөн тэгшлэх ажиллагааг гүйцэтгэнэ.

Нөхөн сэргээлтийн стандартад заасны дагуу хэлбэржүүлэхдээ орчны газрын тогтоцыг харгалzan ойролцоо газрын хэлбэрт аль болох ойртуулан налуугийн өнцгийг үүсгэхийг хичээж ажиллана.

## ЗУРГАА. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх болзошгүй болон гол сөрөг нөлөөлүүдийг тодорхойлоход уурхайн явцад газрын гадарга, газрын хэвлэй, хөрс, ургамал, газрын гүний усан орчин зэрэгт сөргөөр нөлөөлөх нь тогтоогдоо. Иймд төслийг хэрэгжүүлэх үед үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний талаар доорх зөвлөмжийг өгч байна.

### 6.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах

Төслийн агаарын чанарт үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгахын тулд дараах арга хэмжээг авна. Үүнд:

*Тээвэрлэлтээс үүсэх тоосожилтыг бууруулах арга хэмжээний зөвлөмж:*

- 1) Уурхайн олборлолтын үйл ажиллагаанд агаарт тодорхой хэмжээний тоос үүсдэг бөгөөд ашиглалтын талбай нь хүн амын суурьшилт, салхиар дамжин хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхээс сэргийлж уурхайн талбайд усалгаа хийх

- 2) Мөн түүнчлэн сурфактант уусмал, давс, нефтийн эмульс, нийлэг материал, цавуурхаг материалуудыг ашиглаж болно.
- 3) Тээврийн хэрэгсэл, машин тоног төхөөрөмжийн кабинд үйлчилгээ хийх, машин тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийх зэрэг болно.

#### ***Овоолго болон задгай талбайн тоосжилтыг бууруулах зөвлөмж***

Ил уурхайн бүсэд задгай талбай болон овоолгуудыг бий болгодог. Салхины хурд 5.7 м/с хүрэхэд хөрс шорооны жижиг диаметertэй (0.1 мм) эгэл хэсгүүд дэгдэж эхэлдэг [Chepil 1958]. Салхины элэгдэлийг бууруулах хэд хэдэн хүчин зүйл байдаг. Үүнд:

- Хөрсний бүтцэд салхины элэгдэлд тэсвэртэй харьцангуй том ширхэглэлтэй бүрэлдэхүүнүүд байх;
- Шимт хөрс болон, хөрсний овоолгын гадаргууг нягтруулах, гадаргууг тэгш бус болгох, чийгшүүлж байх; эсвэл зүлэгжүүлэх зэргээр тоосжилт үүсгэхгүй арга хэмжээг авах
- Газрын гадарга орчмын салхины хурдыг бууруулах эсвэл хязгаарлах

#### **6.2 Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах**

Төслийн үйл ажиллагаанаас газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахдаа дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн үйл ажиллагааны явцад үссэн газрын гадаргын эвдрэлд өртсөн хэсгүүдэд ажлын явцад төрх байдлын сайжруулалт хийж, ухмал нүх овоолгыг тэгшилж байх.
- Суурингийн талбайд хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд болон тухайн орчиндоо сөрөг нөлөөллийг бий болгох газар ашиглалтыг төлөвлөхгүй байх.
- Төслийн явцад хийгдэх зайлшгүй шаардлагатай газар шорооны ажил, агуулах, үйлчилгээний хэсэг байгуулах зэрэг ажил нь барилга байгууламжийн дэвсгэрээс бусад талбайн газрын гадаргыг өөрчлөлтөнд оруулдаг ч орчны тохижилт, ногоон байгууламжийг зохистой байршуулж асуудлыг шийдвэрлэх боломжтой.
- Төслийн талбайн орчимд ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлцуулахдаа зориулалтын хогийн цэг байгуулан асгаж байх шаардлагатай.
- Газрын хэвлийг төслийн хүрээнээс гадна аль болох бага хөндөх, ажил гүйцэтгэхэд ашиглах талбайг нөхөн сэргээх
- Ногоон байгууламж бий болгох

#### **6.3 Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Элс олборлох уурхайн төслийн үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Төслийн явцад хөрсийг ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдал болон нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх
- Уурхайгаас гарах шороог төслийн дагуу овоолгын талбайд зөв байрлуулан асгаж, дагтаршуулах, хур тунадас, салхины нөлөөгөөр үүсэх хагарал, хотойлт зэргийн шалтгааныг судалж түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байх шаардлагатай
- Авто засварын газрын талбайг тослох материал хөрсөнд нэвчихээс сэргийлж, цардаж өнгөлөх, тэмдэгжүүлэх

- Олборлолт дууссаны дараа техникийн нөхөн сэргээлт хийх
- Техникийн нөхөн сэргээлт хийсэн газрыг өтөг бууцаар бордож, олон наст ургамлын үр цацах, мод бут суулгах зэргээр биологийн нөхөн сэргээлт хийх
- Уурхайн олборлолт, барилга байгууламж байгуулах явцад эвдэрсэн хөрсийг засч тэгшлэх, нөхөн сэргээх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх
- Хөрс хадгалах зориулалттай талбайг сонгохдоо салхи, усны нөлөөгөөр хөрс элэгдэлд орох нөхцлийг хамгийн бага байхаар төлөвлөх
- Шимт хөрсийг хамгаалахын тулд овоолгын өнгөн хэсгийг сэргээх, үүний тулд овоолгын гадаргуугийн хөрсөнд усалгаа хийх, тохиromжит ургамлын үр цацах, гадаргуугийн бүрхэвч бий болгох, хажуу бэлийг хамгаалах зорилгоор геоматериалаар хучих арга хэмжээ авах

#### **6.4 Усны нөөц, чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

- Гол, мөрний байгалийн үндсэн голдирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэргүйгээр өөрчлөхгүй байх ёстой.
- Газрын доорх ус буюу үндны усны нөөцийг бохирдуулагч эх үүсвэр нь хөрсний бохирдол юм. Хөрсөн дээр асгарсан, гоожсон шатах, тослох материал түүний үе давхаргуудад шүүрэн нэвчиж газрын доорх усыг бохирдуулна. Нөгөө талаар бороо хурын ус чийг, хөрсөнд бий болсон дээрх бохирдлуудыг цааш дамжихад ихээхэн нөлөөлөлтэй байдаг тул нэн түрүүн хөрсийг шатах, тослох материалаар бохирдохоос хамгаалах, бохирдсон нөхцөлд нэн даруй арга хэмжээ авч байх шаардлагатай.
- Өөрийн ашиглалтын талбай дахь болон эргэн тойрны хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллана.
- Ажилчид болон төслийн талбай түүний нөлөөллийн бүсэд байх талбай дахь ард иргэдийн үнд ахуйн хэрэгцээний усны чанар нь стандарт, норм, нормативд нийцэх эсэхэд байнга хяналт тавьж ажиллана.

#### **6.5 Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах**

Төслийн явцад ургамлын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах замаар дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- Жил бүр ургамлын мониторинг судалгааг явуулах
- Ашиглалтын талбайн ургамал бүрхэвчийг хамгаалах үүднээс олон салаа зам гаргахгүй байх, маршрутын зам гаргах
- Хог хаягдлыг ил задгай хаяхгүй байх, хогийн нэгдсэн цэг байгуулах, хогийг орчиндоо тархахааргүй байх талаар арга хэмжээ авах
- Ашиглалтын талбайн 10 хувьд ногоон байгууламж бий болгох

#### **6.6 Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арилгах**

- Холбогдох хуулийг нийт ажиллагсадад танилцуулан, нутгийн унаган болоод нүүдлийн ан амьтдыг хамгаалах, амьтны байршил хөдөлгөөнд аль болох нөлөөлөхгүй байх, уулын малталт овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах шаардлагатай.
- Төслийн орчимд элдэв халдварт өвчин тараах хэрээ, жунгаа гэх мэт шувуудыг хэт олшрохоос урьдчилан сэргийлж ил задгай хог хаягдал, хоол хүнсний үлдэгдэл хаяхгүй байх.

- Төслийн талбайд мал, амьтан орж, машин механизмд дайруулж хорогдооос сэргийлж, байнгын хараа хяналт тавих, хашаа, хайс барих
- Уурхайн талбай, түүний орчинд хогийн цэг дээр амьтан тэжээл хайж ирэх, орогнох, үүрлэх нөхцөл үүсгэхгүй байх, ахуйн ба үйлдвэрлэлийн хог хаягдлаас мал, амьтан хордох явдлаас сэргийлэх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.
- Хууль бус ан, агуулж хийхгүй байх

## **6.7 Нийгэм, эдийн засаг, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах**

*Төслийн нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахын тулд:*

- Аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлах
- Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулах,
- Техник, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд байнгын хяналт тавих
- Ажилчдын ажлын байрны аюулгүй орчныг бүрдүүлэх, хүнд нөхцөлд ажиллагсдад нэмэгдэл цалин, урамшуулалт олгох
- Ажилчдын цалинг цаг тухай бүрт нь олгох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

*Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл мэндэд учруулах сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ*

- Ажил эхлэхийн өмнө ажилчдад хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, гэнэтийн осол гамшгаас урьдчилан сэргийлэх яриа таниулга хийж, хөдөлмөр, аюулгүй ажиллагааны самбар ажиллуулах, ажлын хувцсаар хангаж, галын хортой ажиллах заавар өгч, эмнэлэгийн анхны тусlamж үзүүлэх буланг байгуулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байх ёстой.
- Уурхайн ажиллагсдад тусгай зориулалт бүхий амны хаалт, хувцас хэрэгсэл олгох.
- Ажиллагсдыг жил бүр эрүүл мэндийн үзлэгт оруулж, уурхайн ажилчдын өвчлөлтийн талаар судалгаа дүгнэлт гаргах
- Орон сууц, хоолны газар, ажлын байрны эрүүл ахуйд хяналт тавьж ажиллах
- Дуу чимээ ихтэй нөхцөлд ажиллах ажиллагсдад зориулалтын чихний бөглөө олгох
- Эмнэлгийн анхны тусlamж үзүүлэх багаж хэрэгслийг ажлын байруудад зохих шаардлагын дагуу бэлтгэж байрлуулах
- Уурхайн ажилчдад хөдөлмөрийн аюулгүй байдал, аврах багийн хүрээнд сургалтанд хамруулах
- Нутгийн оршин суугчид болон ажиллагсдын эрүүл аюулгүй байдлыг хангах үүднээс бохирын худагтсар бүр хуваарийн дагуу ариутгал, халдвартгүйжүүлэлт хийх.
- Уурхайн тоног төхөөрөмж, ахуйн хаягдал цэг, сав агуулахуудын байрлах газрыг байгаль орчинд халгүй, хүмүүсийн аюулгүй ажиллах, амрах бүх нөхцлийг хангах зорилгоор зөв байрлуулах зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлнэ.

**Үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх гол нөлөөллийн талаар**  
**Хүснэгт 2.2**

**Гол сөрөг нөлөөллийн хамрах хүрээ, эрчим, үргэлжлэх хугацаа**

№	Төслийн гол нөлөөлөл	Нөлөөлөлд өргөгч	Нөлөөллийн эрчим	Үргэлжлэх хугацаа
1	Шимт хөрс хуулалт	Газрын хөрс, бэлчээр, агаар	Хүчтэй	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
2	Элс, хайрга олборлолт	Геологийн тогтоц, агаар	Дунд зэрэг	Тесөл хэрэгжих бүх хугацаанд
3	Тээвэр	Хөрс, агаар	Дунд зэрэг	Төсөл хэрэгжих бүх хугацаанд
4	Овоолго	Хөрс, агаар, шимт хөрс	Хүчтэй	Тесөл хэрэгжих бүх хугацаанд
5	Сийрэгжүүлэлт	Агаар, хөрс	Дунд зэрэг	Сийрэгжүүлэлт хийсэн үед

Элсний ордын олборлолт тухайн бүс нутагт шууд нөлөөлөл үзүүлэхээс гадна энэ процесс нь олборлолт явагдаж байхад болон олборлолтын дараа байгаль нөхөн сэргээлт хийсний дараа ч сөрөг нөлөөлөл нь үргэлжилнэ. Сөрөг нөлөөллийн эрчим нь олборлолт эхэлсэнээс хойш ихсэнэ. Элс-хайрга олборлох үйл ажиллагааны улмаас уулын чулуулгийн тогтоц, гадаргын усны горим, агаарын чанар, гадаргын болон гүний усны хэмжээ, чанар өөрчлөгдөх, хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх зэрэг сөрөг нөлөөллүүд байна.

**Хөрс, геологийн тогтоц**

Шимт хөрс хуулалт, овоолго, тээвэр, сийрэгжүүлэлт зэрэг үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд хамгийн өргөмтгий нь хөрс юм. Мөн уурхайд ашиглагдах хүнд даацын техникуүд, тэдгээрийн тос асгаралт зэрэг олон хүчин зүйл хөрс бохирдох нөхцөлийг бий болгодог.

**ДОЛОО . БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**  
**7.1 СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ, ТҮҮНИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

“Жо интернэшил” ХХК нь холбогдох байгууллагатай харилцан уялдаатай ажилладаг ба тэдгээрээс өгсөн үүрэг даалгавар болон зөрчлүүдээ цаг тухайд нь арилган ажилладаг болно. Манай компани нь Байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2023 онд нийт 13300.0 мян.төгрөгийг зарцуулахаар төлөвлөв. Энд тусгагдаагүй зардлууд нь уулын ажлын болон хөдөлмөр хамгаалалын зардалд тусгагдсан болно Байгаль хамгаалах сургалт болон сурталчилгааг тус орон нутгийн Байгаль хамгаалагч болон БОХГ-тай хамтран зохион байгуулахаар төлөвлөлөө.

СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ЗАРДАЛ

Гол ба болзошгүй сөрөг нөлөө	Үрьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
<b>АГААР ОРЧИН</b>						
Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох	Уурхайн карьер доторх замд хуурайшилттай үед усалж байх	0.6 км зам	-	300.0	2023 он	Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээхэвийн норм, түвшний хэмжээ
	Дизель түлш ашигладаг дотоод шаталт хөдөлгүүрүүд болон машинуудыг ашиглаагүй үед сүл асаалттай байлгахгүй байх, шаардлага хангахгүй байгааг нь шинэчлэх		-	-	2023 он	
	Шимт хөрс болон, хөрсний овоолгын гадаргууг нягтруулах, гадаргууг тэгш бус болгох, чийгшүүлж байх; эсвэл зүлэгжүүлэх зэргээр тоосжилт үүсгэхгүй байх	Овоолго үүсгэх талбай	ҮАЗардалд	-	2023 он	
	Хүнд механизмын хөдөлгүүрийн тохигоо, үйлчилгээг тогтмолжуулах, хөдөлгүүрээс гарах утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах арга хэмжээ авах;	Үйл ажиллагааны турш		-	2023 он	
<b>НИЙТ ДҮН</b>				<b>300.0</b>		
<b>УСАН ОРЧИН</b>						
Ус ашиглах, Ахуйн хаягдал, шатах, тослох материал ба бусад хаягдаас бага гүний уст давхарга	Мэргэжлийн байгууллагаар гүний худаг гаргуулж унд ахуйд шаардлагатай усыг хангах. Гүний худагт тоолуур, хамгаалалтын бус тогтоож ажиллах	Төслийн хүрээнд	ҮАЗ	ҮАЗ	2023 он	

Зүүн эрэг элс хайрганы ордыг ашиглах төслийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

<b>Гол ба болзошгүй сөрөг нөлөө</b>	<b>Үрьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар, хэмжээ</b>	<b>Нэгжийн өртөг /мян.төгрөг/</b>	<b>Нийт зардал /мян.төгрөг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</b>	<b>Баримтлах стандарт, аргачлал</b>
болов хөрс ургамал бохирдох	Гол, мөрний байгалийн үндсэн голдирлыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагын шийдвэргүйгээр өөрчлөхгүй байх ёстой.	Үйл ажиллагааны турш	-	-	2023 он	
	Ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулж ажиллах. Төсөл хэрэгжүүлэгч нь “Усны тухай хууль” -ийн 28.4 -р зүйлд зааснаар “Ус ашиглах дүгнэлт” -ийг аймгийн байгаль орчны албанаас гаргуулна. Ус ашиглах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг Хонгор сумын Засаг даргатай холбогдох гэрээг байгуулж ажиллах шаардлагатай.	Уурхай ажиллах нийт хугацаанд	Ашиглах усны хэмжээгээр	-	Жил бүр ашиглалтын хэмжээгээр	
	Шатах, тослох материалын хаягдал, асгаралт гаргахгүй байх арга хэмжээ авах, төлөвлөлт боловсруулах	Үйл ажиллагааны турш			2023 он	MNS 13.060.50 Усны чанарын стандарт Усны тухай хууль ЗГ-ын 2013 оны 326 дугаар тогтоолын хавсралт –Ус ашигласаны төлбөрийн хувь хэмжээ/ Газар доорх усиг бохирдлоос хамгаалах: MNS3342:1982 БО, ЭМНХ-ын сайдын 1997 оны 143А, 352/A тоот хамтарсан тушаалын 2.3.5 хавсралт,
	Бороо цас үерийн ус цуглуулахсан байгуулах, тоосжилт дарах зорилгоор хэрэглэх, үерээс хамгаалах далан байгуулах	Боломжит газрыг сонгох ажиллах хугацаанд			2023 он	
<b>Нийт дун</b>				-		
<b>ХӨРС, УРГАМЛАН БҮРХЭВЧ</b>						
Хөрс элэгдэл эвдрэлд орж үржил шим, чийг буурах,	Ил уурхай, овоолго байгуулах талбайн үржил шимт хөрсийг хуулж, 2 м-ээс өндөргүй овоолон хадгалах, овоолтыг	Үйл ажиллагааны турш	-	ҮАЗардалд	2023 он	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга,

Зүүн эрэг элс хайрганы ордыг ашиглах төслийн 2023 оны  
Байгаль орчны менежментийн төлөвлөгөө

---

<b>Гол ба болзошгүй сөрөг нөлөө</b>	<b>Үрьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ</b>	<b>Арга хэмжээний цар, хэмжээ</b>	<b>Нэгжийн өртөг /мян.төгрөг/</b>	<b>Нийт зардал /мян.төгрөг/</b>	<b>Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж</b>	<b>Баримтлах стандарт, аргачлал</b>
гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	салхины нөлөөнөөс хамгаалах					MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээMNS 5915:2008
	Уурхайн дотоодтээвэрлэлтийн замыг хайрган хучилттай болгох	Үйл ажиллагааны турш	-	ҮАЗардалд	2023он	
Тээвэрлэлтийн улмаас хөрсний эвдрэл үүсэх	Замыг тэмдэгжүүлж, салаа зам гаргахаас сэргийлсэн ухуулах самбар хийж байрлуулах,	Төслийн талбайд	-	250.0	2023 он	
Ахуйн хаягдал, шатах, тослох материал алдагдах, баяжуулах үйлдвэрийн хаягдлыг зайлцуулах үед хөрс бохирдох	Шатах, тослох материал, ажилласан тосны хаягдлыг зориулалтын саванд хадгалах, орчинд асгарч алдагдахаас сэргийлэх,	Үйл ажиллагааны турш	-	100.0	2023 он	
	ШТМ, агуулах болон засварын төвийн талбайг хатуу хучилттай болгож газрын гадарга, хөрс бохирдохоос сэргийлэх	Агуулахуудын орчимд	-	-	2023 он	
	Хог хаягдлыг тухай бүрт нь ангилан зайлцуулах арга хэмжээ авах	Төслийн талбайд		-	Тухай бүрд	
Нийт зардал				350.0		
<b>Сөрөг нөлөөллийг бууруулах төлөвлөгөөний зардал</b>				<b>650.0</b>		

## НАЙМ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн нөхөн сэргээлтийн ажлаар ил уурхайг ашиглах явцад үүссэн орон зайд байрлах гадаад болон дотоод овоолгыг тэгшлэх, ухагдас, нүхийг хэлбэршүүлэн талбайг тэгшлэх, мөргөгийн ханыг стандартын шаардлагад хүртэл налуулах, тэдгээрийн гадаргыг үржил шимт хөрсөөр хучих зэрэг техникийн нөхөн сэргээлтийг хийнэ.

Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2009 оны 12 сарын 29-ний өдөр баталсан "Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх аргачлал"-ын дагуу гүйцэтгэж нөхөн сэргээлтэнд гарах зардлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайдын хамгарсан 2010 оны 05 сарын 17-ны өдрийн А-132/112 дугаар тушаалтын дагуу хийж гүйцэтгэнэ.

Нөхөн сэргээлтийн ажилд дараах стандарт болон заавруудын шаардлагыг хангах:

- MNS 5915:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилаал
- MNS 5917:2008 Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 4915:2000 Ашигт малтмал эрж хайх явцад эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Техникийн шаардлага
- MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрсийг хуулах, Хадгалах. Техникийн шаардлага
- MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн шаардлага
- MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
- Ашигт малтмал эрж хайх ажлын явцад эвдэрсэн газрыг нөхөн сэргээж ургамалжуулах заавар (БО-ны болон ХААҮ-ийн сайдын 2000 оны- 64/A/62 тоот тушаалтын 3-р хавсралт)

### 8.1 2023 оны техникийн нөхөн сэргээлтийн ажлын хэмжээ, зардал

№	Зардлын утга	Хэмжих нэгж	Ажлын хэмжээ	Ашиглагдах техник, тайлбар	Нэгж ажлын зардал, төг	Нийт зардал, мян.төг
<b>1. Бэлтгэл ажлын зардал</b>						
<b>2. Техникийн нөхөн сэргээлтийн ажил</b>						
1	Ил уурхай, дотоод овоолго					
1	Дотоод овоолгыг түрж тэгшлэх, хэвгийжүүлэх	га	0.6	Утгуурт ачигч	350.0	1500.0
3	Бусад эвдэрсэн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	га	-	-	-	
<b>Техникийн нөхөн сэргээлтийн ажлын дүн</b>		<b>мян.төг</b>				<b>1500.0</b>

## ЕС. ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 онд дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд Төв аймгийн нутаг дэвсгэрт тоосжилтыг бууруулах зорилгоор 1 га талбайд 2500 ширхэг мод , бут сөөг тарина. Энэ ажлын зардал 10.5 сая төгрөг болно.

## АРАВ. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

## **АРВАН НЭГ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Төсөл хэрэгжих бүс нутаг, түүний орчимд хийсэн археологийн судалгаа, түүх соёлын өвийн судалгааны дүн, түүх, соёлын өв дурсгалуудын талаарх нутгийн иргэд, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэн түүх, соёлын өв дурсгалуудыг хамгаалах төлөвлөгөө боловсруулна.

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

## БОЛЗОШГҮЙ АЮУЛ, ОСЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшигийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг /мян.төгрөг/	Нийт зардал /мян.төгрөг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
Болзошгүй осол, saatал, технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Ил уурхайд, барилга байгууламж техник тоног төхөөрөмжид	ҮАЗардалд	-	Өдөр бүр, тогтмол /уурхайн байгаль орчны мэргэжилтэн хариуцна/	Гамшигаас хамгаалах тухай хууль, 27.1  Ил уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх, байгаль орчныг хамгаалах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Нийт ажиллах хугацаанд Уурхайн бүх ажилчдад	-	-	2023 он Жилд 1 удаа	
	Гал унтраах хэрэгслээр бүрэн хангах арга хэмжээ авах,	Төслийн хүрээнд	-	-	2023 он	
	Осол эрсдэл үүссэн үед устгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах	Үйл ажиллагааны турш	200,0	200.0	2023 он	
Хүний эрүүл мэндэд нөлөөлөл үүсэх	Ажилчдыг ажлын хувцас, хамгаалалтын тусгай хэрэгслээр (хөвөн даавуун материалаар хийсэн хувцас, резинэн хормогч, резинэн гутал, резинэн бээлий, хамгаалалтын нүдний шил, маск) хангах	Үйл ажиллагааны турш	ХХАЗардал	-	2023 он	
<b>Нийт дүн</b>			<b>200.0</b>			

### Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал

Болзошгүй сөрөг нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Нэгжийн өртөг	Нийт зардал мян.₮	Хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Хатуу хог хаягдлыг тогтмол зайлцуулаагүй гээс орчин бохирдох	Ахуйн хаягдлыг ангилах дахин ашиглах зүйлсийг цуглуулах цэг байгуулах, нэгдсэн цэгт тушаах арга хэмжээг авч байх	Үйл ажиллагааны турш	70.0	70.0 x 3 сар x = 210.0	Сар бүр	Хог хаягдлын тухай хууль болон холбогдох журам, заалтууд
	Хог хаягдлыг цуглуулах савыг битүүмж сайтай хийх, ажилчдынбайр, тэсрэх материалын агуулах, ШТС зэрэг газарт байрлуулах	Үйл ажиллагааны турш			2023 онд	
	Хаягдал дугуй болон төмрийн хаягдлыг ангилан ялган цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх	Үйл ажиллагааны турш	-	-	2023 онд	
	Хаягдал ажилласан тосыг тусгай саванд цуглуулж дахин боловсруулах үйлдвэрт өгөх	Үйл ажиллагааны турш	Хэрэглээний хэмжээгээ өр	-	2023 онд	
Шингэн хог хаягдаар хөрс, газар доорх ус бохирдож болзошгүй	Бие засах газар, бохирын худгийг MNS 5924 : 2015 "Нүхэн жорлон, угаадасны нүх. Техникийн шаардлага" стандартын дагуу барьж ашиглах	Ажилчдын сууринд	ҮАЗардаалд	-	2023 онд	Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль,
Хийн хаягдал их гарч агаар орчин бохирдож болзошгүй	Агаар бохирдуулах эх үүсвэр тутмын ялгарлыг бууруулах техник технологийн шийдлүүдийг төслийн эхэн үеэс эхлэн шийдвэрлэж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах	Агаар бохирдлын төлбөрийн заалтаар	-	ҮАЗардаалд тусгах	2023 онд	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
<b>НИЙТ ДҮН</b>				<b>210.0</b>		

### БОМТ-г хэрэгжилтийн нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Төсөл хэрэгжүүлэгч "Жо интернэшил" ХХК жил бүр БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн терийн захирагааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

БОМТ, түүний хэрэгжилтийг тайлагнах,	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах чиглэл	Зохион байгуулах газар
Сум, багийн ИНХ	Уулзарт, санал асуулга	БОМТ болон Хяналт, шинжилгээний	11-р сар	Нутгийн иргэдийн саналыг	-
БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тухайн жилийн	Тайланг хүлээн авсан актыг	-	-	-

**Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр**

<b>№</b>	<b>Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд</b>	<b>Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл</b>	<b>Хяналт шинжилгээ хийх байршил</b>	<b>Хугацаа ба давтамж</b>	<b>Шаардагдах зардал (мян.төг)</b>	<b>Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд</b>
<b>Агаарын чанар</b>						
1.1	Агаарын бохирдлын шинжилгээ хийлгэж байх	Уурхайлалт явагдаж буй талбайд	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгох зонхилох салхины доод ба дээд талд			MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988
1.2	Агаарын тоосны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Уурхайн үйл ажиллагаанаас орчинд тоосжилт ҮҮсэх, тархах	Ил уурхайн талбай хөрсний овоолго 2 цэг	Жилд 1 удаа	Шинжилгээний зардал: 1 дээж НИЙТ 80.0	Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009
<b>Хөрсний бохирдол</b>						
2.1	Хөрсний морфологи бичиглэл, pH, цахилгаан дамжуулалт, давс %, ялзмагийн агууламж %, шим тэжээлийн элемент, хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс устэрөгчийн нэгдлүүд	Хөрс элэгдэл эвдрэлд орох, үржил шимээ алдах, гадаргын унаган хэлбэр өөрчлөгдөх	Төслийн талбайд 3 цэг сонгох ШТМ түгээх цэгийн орчим болон олборлолтод өртөөгүй цэг, уурхайн талбайд	Жилд 1 удаа 2дээж	Шинжилгээний зардал: 2 дээж НИЙТ 80.0	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 MNS 3675:1984 лабораторийн арга, MNS 4006:1987 MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар.
2.1	Усны чанар pH, уссан нийт давс (жингийн аргаар), усны ерөнхий болон хунд металлын шинжилгээ	Төслийн талбай орчим	Туул гол	Жилд 1 удаа	НИЙТ 80.0	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. MNS 4586:1998 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага MNS (ISO) 5667-14:2000 авлагын зөвлөмж

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байгаль орчны бүрэлдэхүүнд үзүүлэх нөлөөлөл	Хяналт шинжилгээ хийх байршил	Хугацаа ба давтамж	Шаардагдах зардал (мян.төг)	Баримтлах арга, аргачлал, стандарт, шаардлагууд
<b>Ургамлын аймаг</b>						
3.1	Ургамал устах, ёсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах	Ургамлын төрөл зүйл, бүрхэц, биоамасс, дундаж өндөр, ховор, нэн ховор ургамал	Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчим 2 цэгт	Жилд 1 удаа	-	ШУА Ботаникийн хүрээлэнтэй хамтарч ажиллах
<b>ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН НИЙТ ЗАРДЛЫН ДҮН</b>				<b>24.0</b>		

### **УУЛ УУРХАЙН ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

Хянасан огноо	Шинжээч бөглөнө
Хянасан мэргэжилтэнгүүдийн хувийн дугаар	Шинжээч бөглөнө
Дүгнэлт	Шинжээч бөглөнө
1.1      Шийдвэрийн төсөл	
1.2      Ололт, амжилттай тал	
1.3      Дутагдалтай сул тал	
1.4      Шаардлага	

### **НЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭД, ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- 1.4.1 Байгууллагын нууцын тухай хуулийн 6.1 болон 6.2-ыг үндэслэн дагуу тухайн төслийн хуулийн этгээд мэдээллийн төрлийн харгалзах мөр, багананд мэдээллийг товч хэлбэрээр үнэн зөв оруулах.
- 1.4.2 Тухайн төсөлд хамааралгүй мэдээллийг “хамааралгүй” гэж бөглөнө.
- 1.4.3 1.2.7 дахь хаалтын дараах зориулалт гэдэгт уурхайн хаалтын дараа нөхөн сэргээсэн газрыг бэлчээр, газар тариалан, агуулах, олон нийтэд зориулсан үйлдвэр, үйлчилгээ гэх мэт тухайн газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулахаар төлөвлөж буй бол орон нутагтай урьдчилан тохиролцсон чиглэлийг оруулах.

Маягт ТУ-1.1

**“ЗҮҮН ЭРЭГ” ЭЛС ХАЙРГАНЫ УУРХАЙН /БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭР/ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ**

№	Үзүүлэлтүүд			Тайлбар
1	Аж ахуйн нэгжийн нэр			Жо интернэшил
2	Улсын бүртгэлийн дугаар			9011048043
3	Ордын нэр			Зүүн эрэг
4	Хөрөнгө оруулалт /Улсын нэр/			Монгол
5	Ордын байршил	Aймаг/нийслэл		Төв
		Сум/дүүрэг		Алтанбулаг
6	Ашигт малтмалын төрөл			Элс, хайрга
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар			MV-015042
8	Нөөц	Нөөц бүртгэсэн байгууллага		АМГТГ
		Нөөц бүртгэсэн байгууллагын дүгнэлт, тушаал		04-04 2009.04.02 т/97 2009.04.15
		Нийт хүдрийн хэмжээ		852.809 мян.мз
		Нийтбүтээгдэхүүний хэмжээ		658.288 мян.мз
9	Техник эдийн засгийн үндэслэл	ТЭЗҮ хүлээн авсан байгууллагын дүгнэлт, шийдвэрийн дугаар, огноо		т/20-04-07, 2020.04.22 т/т /84 2020.06.12
		ТЭЗҮ боловсруулсан аж ахуйн нэгжийн нэр		“Роаял Рэнж” ХХК
		Ашиглах нийт хугацаа		10 жил
10	Уурхайн төрөл	Ил		Ил
		Далд		
		Баяжуулах, боловсруулах үйлдвэр		
11	Жилийн хүчин чадал	Хүдэр олборлолт	Хэмжих нэгж	Мян.м <sup>3</sup>
		Бүтээгдэхүүн гаргалт		Мян.м <sup>3</sup>
14	2023 онд гаргах бүтээгдэхүүний хэмжээ	Хүдэр олборлолт	Хэмжих нэгж	Мян.м <sup>3</sup>
		Бүтээгдэхүүн гаргалт		50.0
15	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/ хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр		49.15
		Гар утас		50.0
		Яаралтай үед холбоо барих утас		99116249, 99120031
16	Ашиглалт эхэлсэн огноо			2021

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

**ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ОЛГОГДДОГ ТУСГАЙ  
ЗӨВШӨӨРӨЛ, ДҮГНЭЛТ, ЛАВЛАГААНЫ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

- 1.5 Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай 2.3-ыг үндэслэн хуулийн хуулийн этгээд тусгай зөвшөөрөлтэй холбогдох доорх мэдээллийг үнэн зөв оруулах.
- 1.6 Тусгай зөвшөөрөл, үнэлгээ, дүгнэлтийг баталсан хуулийн этгээд, дугаар, огноог оруулах
- 1.7 Доорх хүснэгтийн 2.1.9, 2.1.10-т тусгагдсан холбогдох 7 материалын хуулбарыг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зайлшгүй хавсаргах. Мэдээлэл оруулах багананд хавсралтын нэрийг оруулах.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
2.1	1. Тусгай зөвшөөрлийн төрөл /ашигт малтмал/	Элс хайрга MV-015042
	Дугаар	-
	Хүчинтэй хугацаа	29.97га
	2. Тусгай зөвшөөрлийн төрөл /химийн бодис ашиглах/	-
	Дугаар	-
	Хүчинтэй хугацаа	-
	3. Химийн бодисын агуулгад хийсэн мэргэжлийн хяналтын газрын тодорхойлолт	-
	4. Галын дүгнэлтийн огноо, дугаар	-
	5. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний огноо, баталсан хуулийн этгээд	2020 БОАЖЯамны ерөнхий шинжээч Тэмүүлэн
	6. Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний огноо, хийсэн хуулийн этгээд	2020 “Team смайл “ ХХК
	7. Ус ашиглалтын дүгнэлтийн огноо	-
	8. Тухайн жилийн уулын ажлын батлагдсан төлөвлөгөөний огноо	2023 он

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

## ГУРАВ. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛ, ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

1.4.4 Байгаль орчин ногоон хөгжлийн сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрын А-05 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 2 дугаар хавсралтанд тусгагдсанг тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгад заагдсны дагуу химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэсгээс холбогдох доорх мэдээллийг оруулах

1.4.5 Тухайн жилд олон төрлийн химийн бодис ашиглахаар бол байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд хавсралтаар оруулж хүснэгтийн 3.1.1-д хавсралтын нэрийг дурдах /хэмжих нэгжийг дурдсан байх шаардлагатай/

1.4.6 Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөөнд дараах мэдээллийг бүрэн тусгасан тохиолдолд 3.1.2-ын мэдээлэл оруулах хэсэгт “хангалттай” гэсэн дүгнэлтийг оруулна.

- 3.1 урьдчилан сэргийлэх арга хэмжээ
- 3.2 эрсдлийн үед авах арга хэмжээ
- 3.3 учруулсан хор уршгийг зайлцуулах, бууруулах арга хэмжээ
- 3.4 хохирлын нөхөн төлбөрийг тооцох арга хэмжээ

1.4.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд тухайн жилд гарах ахуйн хатуу болон шингэн хог хаягдлыг хэрхэн устгах, зайлцуулах арга хэмжээ, давтамж, мониторингийн арга хэмжээг тусгах, хуванцар, резинен материал /дугуй, сав баглаа боодол/ зэрэг хог хаягдлыг дахин ашиглах цэгт хүргэх хуваарь, аюултай хог хаягдлыг хадгалах агуулах арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээлэл оруулах багана
3.1	1. Тухайн жилд ашиглах химийн бодисын нэр, хэмжээ /хэмжих нэгж/	-
	2. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
3.2	1. Шатах тослох материалын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	Агуулах байхгүй
	2. Тэслэх, дэлбэлэх бодисын нэр хэмжээ /хэмжих нэгж/ агуулах байгаа эсэх	

3.3.	1. Тухайн жилийн хог хаягдлын жилийн дундаж хэмжээ /хэмжих нэгж/  1.4.8 Ахуйн хог хаягдал /хатуу, шингэн/ 1.4.9 Үйлдвэрийн хог хаягдал /хатуу, шингэн/ 1.4.10 Аюултай хог хаягдал	Хатуу хог - 1тн Хатуу төмөр - Резин дугуй г.м Ажилласан масло, гидро шингэн - 200л
	2.Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	210.0 мян.төг

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

### **ДӨРӨВ. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙН ЖИЛИЙН ТӨСӨВ**

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Хөрөнгийн хэмжээ мян/төг	Хугацаа
1	Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ /хөрс, ус, агаар, ургамал, ан амьтан/	Мян төг	650.0	2023
2	Нөхөн сэргээлтийн зардал	Мян төг	1500.0	2023
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	10500.0	2023
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	-	2023
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	Мян төг	-	2023
6	Болзошгүй аюул, ослын менежментийн төлөвлөгөө	Мян төг	200.0	2023
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	Мян төг	210.0	2023
9	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	Мян төг	240.0	2023
	Дүн		<b>13300.0</b>	2023

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

## ТАВ. МЕТА МЭДЭЭЛЭЛ

1.8 Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 39.1.7-д заасныг үндэслэн төсөл хэрэгжүүлэгчээс доорх хүснэгтэнд тусгагдсан төслийн дэд бүтэц, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний цар хүрээ, орчны хяналт шинжилгээний цэгэн мэдээллийг тусгасан мета мэдээллийг цаасанд өнгө будаг, таних тэмдэгээр буулгасан хэлбэрээр болон файл хэлбэрээр тайланд хавсаргах.

1.9 Доорх хүснэгтийн мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах баганыг шинжээч бөглөнө.

д/д	Мэдээллийн төрөл	Мэдээллийг бүрэн тусгасан эсэхийг шалгах багана
5.1	<p>Зурган мэдээлэлд тусгах мэдээлэл</p> <p>1.4.11 Тосгон</p> <p>1.4.12 Дэд бүтэц (зам, өндөр хүчдэл, цахилгаан сүлжээ, шугаман хоолой, станцын байршил, хашаа, тусгаарлагч, үерийн хамгаалалтын далан, аянга зайлцуулагч гэх мэт)</p> <p>1.4.13 Хог хаягдлын цэгийн байршил</p> <p>1.4.14 Хог хаягдлын агуулахын байршил</p> <p>1.4.15 Хог хаягдлын далан</p> <p>1.4.16 Химийн бодисын агуулахын байршил</p> <p>1.4.17 Орчны хяналт шинжилгээний дээж авах хяналтын цэгийн байршил</p> <p>1.4.18 Тухайн жилд хуулах хөрс</p> <p>1.4.19 Гадаад, дотоод овоолго</p> <p>1.4.20 Техникийн нөхөн сэргээлтийн талбай</p> <p>1.4.21 Биологийн нөхөн сэргээлтийн талбай</p> <p>1.4.22 Гүний худгийн байршил</p> <p>1.4.23 Дүйцүүлэн хамгааллын байршил</p>	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

**ЗУРГАА. ТУХАЙН ЖИЛИЙН АРГ АХЭМЖЭЭНЭЭС БАЙГАЛЬ ОРЧИНД  
ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

1.10 Байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нөлөөллийн дүн шинжилгээний хэсгээс доорх хүснэгтийн А, Б, В, Г дэхь багананд “тодорхойлсон”, “тодорхойлоогүй” “хамааралгүй” гэсэн 3 төрлийн хариултаас сонгож бөглөх.

1.11 Дүгнэлт гэсэн багана дахь дүгнэлтийг байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнийн нөлөөллийн дүн шинжилгээний хэсэгт Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны мэрэгжилтэн дүгнэлт гаргана.

<b>Нөлөөллийн ангилал</b>	<b>A. Тооцсон эсэх</b>	<b>Б. Нөлөөллийн цар хүрээг тодорхойлсон эсэх</b>	<b>В. Нөлөөл- лийн эрчмийг тодорхойл сон эсэх</b>	<b>Г. Нөлөөллийн үргэлжлэх хугацааг тодорхойлсон эсэх</b>	<b>Дүгнэлт</b>
6.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - Эвдэх - Доройтуулах	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлоогүй Тодорхойлоогүй Тодорхойлоогүй	Тодорхойлсон Тодорхойлсон Тодорхойлсон	
6.2. Гадаргын болон гүний усанд үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	
6.3. Амьтан, ургамалд үзүүлэх нөлөөлөл - амьдрах орчинг хуваах - амьдрах орчинг доройтуулах - амьдрах орчинг хомсдуулах - нөөцийг	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй Хамааралгүй	
6.4. Агаарт үзүүлэх нөлөөлөл - Бохирдуулах - тоос	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	Тодорхойлсон Тодорхойлсон	
6.5. Түүх соёлын дурсгалт эд зүйлс - Хамгаалах - Нүүлгэн	Тодорхойлсон Хамааралгүй	Тодорхойлсон Хамааралгүй	Тодорхойлсон Хамааралгүй	Тодорхойлсон Хамааралгүй	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг

/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

## ДОЛОО. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ

### ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХЯНАЛТ

1.4.24 Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “А” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

1.4.25 Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийн “Б”, “В”, багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг тогтоосон эсэхэд “тийм”, “үгүй” хариулт өгнө.

1.4.26 Доорх хүснэгтийн “Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, хэмжих нэгжийг оновчтой тогтоосон эсэхэд Байгаль орчин, ногоон хөгжлийн мэргэжилтэнгүүд “хангалттай” “хангалтгүй” гэсэн дүгнэлт өгнө.

Тухайн жилийн байгаль хамгаалах арга хэмжээний чиглэл	A. Тоо	Б. Шалгуур үзүүлэлтийг тогтоосон эсэх	В. Шалгуур үзүүлэлтийн хэмжих нэгжийг тогтоосон эсэх	Г. Дүгнэлт
7.1. Нөлөөллөөс урьдчлан сэргийлэх зайлзуулах арга хэмжээ		Тийм	Тийм	
7.2. Нөлөөллийг бууруулах арга хэмжээ		Тийм	Тийм	
7.3. Нөхөн сэргээлтийн арга хэмжээ 3.5 техникийн/ га эзэлхүүн	1.0	Тийм	Тийм	
7.4. Дүйцүүлэн хамгааллын арга хэмжээ	-	-	-	
7.5 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад		Тийм	Тийм	
7.6. Түүх соёлын дурсгалт эд зүйлийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ	-	Үгүй	Үгүй	
7.7. Байгаль орчны менежментийн удирдлага зохион байгуулалтын арга		Тийм	Тийм	

Мэдээлэл үнэн зөвийг баталсан хүний гарын үсэг  
/......./

огноо

/..... он .... сар .. өдөр /

**НАЙМ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЯНАЛТЫН ХУУДАС**

Төсөл хэрэгжүүлэгч нь доорх хүснэгтийг “А, Б, В, Г” багананд байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг тоогоор илэрхийлэх

Хяналт шинжилгээний дээж	А. Дээж авах цэгийн тоо	Б. Дээж авах цэгийн байршил	В. Давтамж	Г. Төсөв Мян.тог
Хөрс	2	Уурхайн эвдрэлд орох талбай	Жилд 1 удаа	80.0
Ус	1	Уурхайн карьераас ус гарсан тохиолдолд	Жилд 1 удаа	80.0
Ургамал	-	Уурхайн дэвсгэр нутаг	-	-
Агаар	2	Уурхайн эдэлбэр	Жилд 1 удаа	80.0